

ДЭ ВАН ЯПОНЧУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ ЭХЭЛСЭН НЬ

*Д.Зоригт**

Японы Квантуны армийн штабаас 1933 оны 7 дугаар сарын 16-нд “Монголчуудыг жолоодох чиглэлийн товч төсөл” гэгчийг гаргаж, түүндээ “Өвөр Монголын баруун хэсэгт энх тайван, соёлын ажиллагааг голлон ялангуяа эдийн засгийн харилцаагаар тэднийг жолоодож, сайн дураараа Япон Манжийг дотночилдог болгох, Хятадаас хөндийрөх чиглэл баримталсан өөртөө засах засгийн газрыг түргэн байгуулах хэрэгтэй” гэж заажээ. (1, 63) Монголчуудын дунд ажиллах “Нөхөрсөг хөршийн нийгэмлэг” нэртэй байгууллага Токиод 1934 оны 1 дүгээр сард буй болж, маш өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулан, монгол оюутны хэлтэс байгуулж, оюутан элсүүлэх ажил зохиож, оюутны байр барьжээ. Тус нийгэмлэгийн салбар нэгжүүдийг Цахар, Шилийн гол, Долон нуур болон зарим хошуудад буй болгож, хүн мал эмнэлгийн тасаг, бага сургууль нээж, эмчилгээний баг байгуулан орон нутгуудаар ажиллуулж эхлэв. Энэ үйл ажиллагаа өргөжин баруун тийш тэлсээр байлаа. Япончууд 1934 оны 5 дугаар сард Бэйсийн сүмд тагнуулын байгууллага байгуулж, Моричима даргаар нь томилогдов. Намар нь Морчима, Накажима нар Сөнид баруун хошуунд очиж Дэ ванд бараалхан Квантуны арми тэдэнд үнэ төлбөргүйгээр зэвсгээр тусална гэж амлав. Мөн 11 дүгээр сард Квантуны армийн тагнуулын байгууллагын дарга хошууч-генерал Добихара Кэнжи Дэ вантай уулзжээ. Дараа нь хурандаа Ишимото, ахлах зөвлөх дэд хурандаа Танака нар 1935 оны 5 дугаар сард Сөнид баруун хошуунд очиж Дэ вантай уулзан Квантуны арми түүнд туслан Монгол улс байгуулж болно гээд тэнд тагнуулын байгууллага байгуулжээ. (1, 70) Энэ үед япончууд “Манж Монголын бодлого” гэгчээ идэвхжүүлэхийн тулд Дэ ванд ийнхүү анхаарлаа хандуулж, түүнийг аргадан татах ажил хийж байв. Японы армийн тагнуулч Сасамэ 1934 оны эхээр нутагтаа буцаж Дэ вантай ажилласан байдлаа төвдөө илтгэжээ. Тэрээр “Нөхөрсөг хөршийн нийгэмлэг”-ийн шугамаар удалгүй Маикава, Нонака зэрэг хүмүүсийг дагуулан Сөнид баруун хошуунд эргэн ирэв. Тэд Дэ ванд радио, цахилгаан холбооны хэрэгсэл бэлэглэж, зарим хошуунд “Нөхөрсөг хөршийн нийгэмлэг”-ийн салбарыг байгуулаад эрүүлийг хамгаалах болон соёлын ажил эрхлэхээр халхавчлан тагнуулын үйл ажиллагаа

* Д.Зоригт - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

явуулж эхлэв. Сүүлд нь Токиогийн “Нөхөрсөг хөршийн нийгэмлэг”-ийн дарга нь Дэ вангийн айлчлахаар ирсэн бөгөөд түүний дэмжлэгээр арваад залуусыг Японд сургахаар явуулжээ. Зун нь Японы томоохон тагнуул Моричима Какукабаши Бат хаалга сүмд ирж, манай улсаас очсон Дилав хутагт тэргүүтэй хэсэг хүмүүсийн дунд сууж байхад нь Дэ ван Хань Фэнлинь (Хөхбаатар)-тэй хамт очиж, түүнтэй нууцаар уулзсан байна. Тэрээр Квантуны армиас Дэ ванд үнэ өртөггүйгээр өгсөн хоёр мянган винтовыг тээвэрлэж авчирснаа хэлсэнд даруй унаа гарган Жэхэ мужаас авахуулжээ. (8, 71)

Наймдугаар сард Дэ вангийн дотнын хүн, “Монголын засгийн явдлын зөвлөл”-ийн Амрыг хамгаалах газрын нэгдүгээр хэлтсийн дарга Хань Фэнлинь (Хөхбаатар) эмчилгээ хийлгэхээр Бээжинд очихдоо Гоминьданы тусгай албаныханд хорлогдсон байна. Түүний хорлогдсон шалтгаан нь Японд цэргийн сургууль төгссөн тул Дэ ван түүнийг хэлмэрчээр ашигласныг нь япончуудтай нийлсэн гэж үзсэн, мөн Наньжинд цэргийн бэлтгэл хийж байхад нь Зян Зиэши-гийн “Хөх хувцаст хороо” хэмээн нэрлэгдэж байсан тусгай албанд ажиллуулах гэхэд нь татгалзсан зэрэг хэд хэдэн зүйлд байжээ гэж хятадын судлаачид үзсэн байдаг. Энэ үед монголчуудын бүх үйл ажиллагаа Гоминьданы тусгай албадын хатуу хяналтанд байсан нь тодорхой юм. Намар нь Тяньжин дахь тагнуулын байгууллагын дарга Доихара Кэнжи онгоцоор хошуунд нь ирж Дэ вантай уулзаад туслалцаа шаардлагатай бол хэл гэхэд нь Хөхбаатарын хорлогдсон шалтгааныг тодорхой мэдэхийг хүсч байгаагаа хэлжээ. Хожим нь уг хэргийн нарийн учрыг япончууд түүнд тодорхой танилцуулсан байна. Хөхбаатарыг Зян Зиэши-гийн тушаалаар түүний тусгай албаныхан буудан хороосныг Дэ ван мэдээд булшийг нь ухан авч, гашуудлын ёслол үйлдэн, дэслэгч-генерал цол нэхэн шагнаад дахин тусгайлан оршуулсан байна. Хөхбаатар үндэстнийхээ төлөө туштай тэмцэгч байсан тул Гоминьданыхны дургүйг ихээхэн хүргэснээс алуулсан гэдэг нь тодорхой харагддаг. Зян Зиэши хамгийн итгэлтэй хүнийг нь алуулсан учир Дэ ван түүнд маш их дургүйцсэний дээр Баруун гүний хошууны хэрэг болон гаалийн асуудлаар Суйюаний эрх баригчидтай сөргөлдөж дийлдсэндээ нэн бухимдаж байв. Иймээс тэрээр япончуудтай харилцаж, тэднийг түшиглэн хүчээ зузаатгаж “Монгол улс” байгуулах талаар бодох болжээ.

Японы цэрэг 1935 оны нэгдүгээр сард Цахар мужид түрэмгийлэн орж ирэхэд Дэ ван Манжийн цэргийн зарим эрхтэн болон Долон нуур дахь Японы тагнуулын байгууллагын дарга нарт нууц захидал илгээж,

тэдний дэмжлэгээр Өвөр Монголын зүүн орны чуулган хошуудаас цэрэг татаж, агт худалдан аваад нууцаар цэргийн бэлтгэл хийж, нэг хороо байгуулав. Квантуны армийн Монголын хэрэг эрхлэх газрын хоёрдугаар хэлтсийн дарга Ишимото Доразо болон офицер Танака Такаёши нар Сөнид баруун хошуунд ирж Дэ Вантай уулзан нууц хэлэлцээр хийхдээ “Манай япончууд манж нарт тусалж Манж улсыг байгуулсан. Одоо та нарт тусалж Монгол улсыг байгуулна. Үүнээс хойш Япон, Монгол, Манж гурав хамтран ажиллах болно...” гэж ярьсан байна. (9, 173)

Энэ үед Бээжингийн томоохон сонинуудын сурвалжлагч нар түүнээс ярилцлага авахад тэр япончууд Өвөр Монголд цахилгаан мэдээний газар байгуулж, мэдээлэл цуглуулж байгааг дурдан ярьж, тэр нь нийтлэгдсэн тул ЭСЯ-ны цэргийн атгаше Дэ вантай биечлэн уулзаж, нууц задрууллаа хэмээн зэмлээд хойшид Япон Монголын хамтын ажиллагаагаа бэхжүүлж, Дундад улстай дахин харилцах хэрэггүй гэж шууд тулгасан байна. Дэ ван Бээжингээс буцахынхаа өмнө хийлгэсэн хэвлэлийн бага хурал дээрээ “Эх оронд аюул гамшиг тулгарч, үндэстнүүдийн оршин тогтнох явдал баталгаагүй болсон энэ үед бид улс ба үндэстнийхээ төлөө үнэнхүү бүлгэмдэн нягтарч өөртөө засах, гадаадын дарлалыг эсэргүүцэж оршин тогтнохоо бодолхийлэх хэрэгтэй. Энэхүү ер бусын цаг үед Өвөр Монголын өөртөө засах явдал үгүй байж болохгүй. Ийм ажиллагаа гарахгүй байж ч болохгүй ...” гэж хэлсэн байна. (9, 177)

Квантуны арми Суйюань-ийг эзэлж баруун тийш түрэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд Нодаира, Шиёотэсэку нарыг тусгайлан томилж ажиллуулсан бөгөөд Дэ ванд нэг нисэх онгоц бэлэглэв. Мөн төмөр замын нэгэн компани түүнд кино зураг авах, кино гаргах аппарат бэлэглэсэн байна. Энэ үед Дэ ван Бат хаалга сүмд овооны наадам хийхэд дотоод гадаадын олон хүн оролцсон бөгөөд Япон, АНУ, Англи, Германы сурвалжлагч нар ирсэн байв. Наадмын дараа сурвалжлагч нар Долон нуурт очих үед Английн сурвалжлагчийг Японы цэргийнхэн нууцаар хорлов. Үүнийг монгол газарт үйл ажиллагаа явуулахгүй байхыг гадаадын бусад орнуудад анхааруулсан япончуудын дохио гэж тухайн үед үзэж байв.

“Өвөр Монголд авах арга хэмжээний хөтөлбөр”-г заасан чиглэл, төлөвлөгөөний дагуу 1935 оны 9 дүгээр сард Квантуны армийн штабын даргын орлогч Итагаки Сзиширо, тасгийн дарга Кавабэ, зөвлөх Танака зэрэг хүмүүс Үзэмчин баруун хошууны вангийн ордонд Содномравдан Дэ ван нартай уулзаж хэлэлцээ хийжээ. (1,72) Дэ ван зүүн баруун

Монголыг нийлүүлж тусгаар тогтносон Монгол улс байгуулахад туслахыг япончуудаас хүсч байгаагаа илэрхийлэхэд тэд Япон улс үүнд туслах сонирхолтой гээд “Гэвч зүүн орны Монгол бол Манж улсын нутаг дэвсгэрт байгаа. Манж улс нь тусгаар тогтносон болохоор би үүнд хариулах эрхгүй. Харин та нарын улс байгуулахад туслахын тулд гурван зөвлөх томилж болно” гэсэн байна.

Дэ ван 1935 оны 12 дугаар сард Дилав хутагт, Тогтох болон Шишимура, Акашима зэрэг японы тагнуулчдын хамт “Манж улс”-ын шинэ нийслэл буюу одоогийн Чанчунь-д онгоцоор ирж, Квантуны армийн командлагч хурандаа-генерал Минами Жироо, штабын дарга Нишиёо нартай уулзаад дараа нь холбогдох хүмүүстэй хоёр талын хамтын ажиллагааны асуудлаа ярилшав. Тэрээр Манж улсаас зүүн Монголын чуулган хошуудад авч явуулж байгаа арга хэмжээг шүүмжилж, Японоос Өвөр Монголд туслан тусгаар тогтносон байдлыг буй болгоод дараа нь Монголыг нэгдсэн улс болгож өгөхийг хүссэн байна. Япончууд үүнийг нь болно хэмээн зөвшөөрөөд 500 мянган иен, таван мянган буу өгөхөөр амлав. (2, 12) Үүний дараа тэрээр Пу И-тэй уулзаж баяр хүргээд шинэ нийслэлээс буцах үед нь Оросын цагаантнуудын толгойлогч Семёнов тэдэн дээр ирж хэдэн үг солиход нь япончууд нэлээд дургүй байдалтай байхыг хажууд нь суусан Дилав хутагт ажиглан хэлж уулзалтыг даруй дуусгажээ. Түүний япончуудтай ийнхүү сүлбэлдэж байгааг Гоминьданы засгийн газар аль хэдийнээс мэдсэн боловч Зян Зиэши Японыг эсэргүүцэхгүй гэсэн бодлого явуулж байсан болохоор таслан зогсоохыг яараагүй бололтой. Гэвч Гоминьданы тусгай албад энэ бүхнийг нарийн хянаж байсан нь эргэлзээгүй юм.

Дэ ван Чанчунь-аас буцаж ирээд япончуудтай хамтран ажиллах болсон тухайгаа Ёндонванчиг ванд танилцуулж, зөвлөн ярилцаад Шилийн голын чуулганд Монгол цэргийн ерөнхий жанжин штаб байгуулахаар тохиролцжээ. Бат хаалга дахь “Засгийн явдлын зөвлөл”-ийг удирдах байгууллага болговол Суйюань мужийн эсэргүүцэлтэй тулгарана гэж үзээд ийм шийдвэр гаргасан байна.

Япончууд Хятадын зүүн хойт дөрвөн мужийг эзэлсний дараа Долон нуурт цагдан сэргийлэх цэргийн жанжин штаб байгуулж, Ли Шоусинь-ийг командлагч болгож, гурван дивиз цэрэг захируулсан бөгөөд 1935 оны өвөл түүгээр Зүүн цахарт халдлага хийлгэсэн байна. Дэ ван “Монголын засгийн явдлын зөвлөл”-ийн нэрээр “Цахарын чуулганы захиргаа”-г байгуулж, Зодовжавыг даргаар, Дамирансүрэнг дэд даргаар томилоод 1936 оны нэгдүгээр сарын 1-нд ёслол хийв.

Монгол-Түвэдийн хороонд ажиллаж байсан У Хэлин Зян Зиэшигээс япончуудыг баруун тийш довтлохыг хориглох, эс чадвал хойшлуулах даалгавар авч, Гоминьданы төв хорооны гишүүн Ням-Осорын хамт Өвөр Монголд ирэхээр бэлтгэж байх үед нь түүнийг япончууд хороохоор зэхэж байгааг Дэ вангийн хүмүүс олж мэдсэн байна. (9, 200) У Хэлин нь Хорчин баруун хошууны ардын баатар гэгдэж байсан Ламжавын хүү юм. Энэ үед тэрээр хууль улс төрийн дунд сургууль төгсөөд Дотоод явдлын яам болон Монгол-Түвэдийн сургуульд алба хашихын зэрэгцээгээр Бээжингийн их сургуульд эчнээгээр сурч байв. У Хэлин нь угийн үндэсний үзэлтэй хүн бөгөөд насаар ч Дэ вантай ойролцоо. Тэд улс төрийн тавцанд өрсөлдөж, хамтран ажиллаж явсан хүмүүс юм. (4, 183) Дэ ван У Хэлин-г ихэд үнэлдэг байсан тул энэ асуудлыг Дилав хутагттай зөвлөн ярилцаад түүнийг хамгаалан авч үлдэх арга боловсруулжээ. Ингээд У Хэлин-г ажилдаа туслуулахаар дуудан ирүүлж байгаа юм гэж японы тагнуулынханд хэлээд, түүнийг Бээжингээс Захчидсэцэний хамт Жанбэйд ирэхэд нь цэрэг явуулж хамгаалуулан вангийн ордондоо авчруулсан байна. Гэтэл тэднийг ирсний дараа Японы тагнуулынхан Ням-Осорыг машинаар явж байхад нь шууд буудан алж, цогцсыг нь замын хажууд хаясан байжээ. Ням-Осор нь Сахарын Мянган хошууны бүгдийг захирагч амбан бөгөөд Монголын засгийн явдлын зөвлөлийн гишүүн байв. Тэрээр япончуудтай нийлэхийг эсэргүүцэж байсан тул ийнхүү алагджээ.

“Монгол цэргийн ерөнхий жанжин штаб”-ыг байгуулах ёслолын ажиллагаа 1936 оны 2 дугаар сарын 12-нд Дэ вангийн ордонд болж Дилав хутагт, Манж улсаас тусгайлан уригдсан Сандүүрэн, Нямдалай, Төмөрбаатар, Бээжингээс уригдсан Тэгшбуян, Сайнбилэгт, Наст, Хөхчин нар болон Японы талаас Шишимура, Маикава зэрэг хүмүүс оролцов. Том гэрийн хойморт Чингис хааны хөргийг ёсчлон байрлуулж, ширээн дээр есөн бүхэл хонины шүүс тавьжээ. Гэрийн гадна баруун дээд өнцөгтөө улаан, шар цагаан гурван өнгийг оруулсан хоёр хөх туг мандуулав. Монгол цэргийн ерөнхий жанжин штаб Чингис хааны оны цол ба он тооллыг хэрэглэхээр тогтсон байна. Энэ жил нь Чингис хааны он тооллын 731 дүгээр он байв. (8, 99) Энэ нь оны цолыг халж, тугаа солин Дундад иргэн улсаас салж, монголчууд тусгаар тогтнон эзэн мэдэх замаар явахыг бэлэгдсэн байлаа. Ёслол дээр Дэ ван тангарагийн үг хэлэхдээ “Би Чингис хааны агуу их зориг санааг дуртайяа залгамжилж, Монголын төрөлх газар нутгаа эгүүлэн авч, үндэстнээ дахин мандуулах их үйлсийг бүтээнэ” гэжээ. Ёслолд Квантуны армийн штабын дарга Нишиёо онгоцоор ирж оролцон баяр хүргэж үг хэлсэн байна.

“Монгол цэргийн ерөнхий жанжин штаб” нь дарга, дэд даргатай, дороо цэргийн ба засгийн явдлын хоёр яам, нарийн бичгийн газартай байгуулагдав. Цэргийн явдлын яам нь гурван газартай, Засгийн явдлын яам нь дотоод явдал, эдийн засаг, соёл сурган хүмүүжил зэрэг гурван газартай, нарийн бичгийн газар нь захиргаа, боловсон хүчин, санхүү зэрэг нэгжүүдтэй байхаар тогтоосон бөгөөд дэргэдээ япончуудаас бүрдсэн зөвлөх нэгжтэй аж. Даргын албан тушаалыг Дэ ван хариуцаж, засгийн явдлын яамыг хавсран удирдах болжээ. Нарийн бичгийн газрын даргаар Буяндалайг ажиллуулахаар болж, бусад албан тушаалуудад Дэ вангийн итгэлтэй хүмүүс томилогдов. Ингээд цэрэг татах ажил хийлгэхээр орон нутагт хүмүүс томилон ажиллуулж эхлэв.

Гэтэл “Монголын орон нутгийн засгийн явдлын зөвлөл”-ийн Амрыг хамгаалах анги Дэ вангийн япончуудтай хамтран ажиллаж эхэлсэн явдалд дургүйцэж, ХКН-аас зохиосон улс төрийн ажлын нөлөө болон Суйюаний эрх баригчдын хатгалгаар бослого гаргаж, Бат хаалга сүмээс гарч яван хятадын цэрэгт зэвсгээ хураалгасан байна. (7, 19) Уг бослогыг Суйюань мужийн эрх баригчид эртнээс төлөвлөж зохион байгуулсан бөгөөд Дэ ван энэ ангийнхаа гол удирдах хүмүүсийг Сенид баруун хошуундаа аваачиж “Монгол цэргийн ерөнхий жанжин штаб” байгуулах бэлтгэл ажлаа хийлгэж байсан үеийг тэд ашиглаж чадсан байна. Тэд төлөвлөсөн ёсоороо цэргийн агуулахыг нээж, зэвсэг булаан мөрдөн байцаах газрыг дайрч, даргыг нь алаад хоригдож байсан хүмүүсийг суллав. Нэг хэсэг нь Амрыг хамгаалах газрын кадр бэлтгэх ангийг дайрч цохин Дэ вангийн хамгаалах ангийн сургагч, сурагчдын зэвсгийг хураасан байна. Зарим хэсэг нь холбооны хэрэгслийг эвдэж, Бат хаалга сүм болон Сенид баруун хошуун дахь Дэ вангийн харилцааг таслав. Мөн Бат хаалгад үлдсэн Дэ вангийн гол хүмүүсийн суугаа газрыг бүслэн, зэвсгийг нь хураахын хамт санхүүгийн албаны мөнгөний авдрыг онгойлгож данс тооцоог шатаасан байна. Энэ ангийн мянга гаруй цэргийг дараа нь Гоминьданыхан “Монголын Амрыг хамгаалах ерөнхий анги” нэрээр зохион байгуулжээ. Ингээд Бат хаалга сүм дэх “Монголын орон нутгийн өөртөө засах засгийн явдлын зөвлөл” аажимдаа үгүй болсон байна. Хятадын Коммунист намын Өвөр Монгол дахь байгууллага япончууд Дэ ван нарыг ашиглан Өвөр Монголыг түрэмгийлэх зэвсгээ болгохоор санаархаж байна хэмээн үзэж сэрэмжилж байжээ.

Энэ үед япончууд Сенид баруун хошуунд ажиллаж байсан тагнуулын байгууллагын даргаар хошууч Асами-г томилсон бөгөөд

тэрээр монгол ажилтнуудад маш харгис хэрцгий байдлаар ханддаг байсан тул түүнийг эсэргүүцсэн хүмүүсийн гомдол тасрахгүй байв. Монголчуудын дунд ч Японы тагнуулын байгууллагын үүрэг даалгаварыг биелүүлж, тэдэнд үйлчилдэг хүмүүс байсан нь тодорхой юм. Дэ ван өөрөө ч энэ хүний ажиллагаа, арга барилд дургүйцэж дотнын хүмүүстэйгээ зөвлөн, “эв нэгдлээ чангатгаж, удирдагчаа хүрээлж, дотоодын зальхайг арилган, гадаадын хүчирхийллийг эсэргүүцнэ” гэсэн гол агуулгатай тангараг бичүүлж, нуудаар хурал хийн түүнийгээ Чингис хааны зургийн өмнө уншин гарын үсэг зурцгааж, цусан тангараг хийв. Үүнд түүний хамгийн дотнын кадр ажилтнууд оролцжээ. (10, 57)

Квантуны арми 1936 оны эхээр Танака Такаёши, Ёкияма Осамо нарыг Сенид баруун хошуунд томилон явуулсан байна. Дэ ван нар энэ үеэр баруун Монголын ван гүн нарын хуралдааныг зарлан хуралдуулж, “Монголын цэргийн засгийн газар” байгуулах ба цаашид “Монгол улс” байгуулах тухай төслийг тус тусд нь хийлгэсэн байна. “Монгол улс” байгуулах төсөлд нутаг дэвсгэр бүрэн бүтэн байж, эзэн мэдэж тусгаар тогтнон, Ар, Өвөр Монгол ба Хөх нуурыг багтаасан урьдын чуулган хошуудаар нутаг дэвсгэрээ болгож, Хао Лудоугаар боомт болгоно гэж тусгав. (2, 16)

Ингээд 1936 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр анх удаагийн “Монголын их хурал” Шилийн голын чуулганы Үзэмчин баруун хошууны вангийн ордонд хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Ар, Өвөр Монгол ба Хөх нуураас бүрдсэн “Монгол улс” байгуулах тухай
2. Хаант ёс байгуулахаас өмнө түр гишүүдийн дүрэм хэрэгжүүлэх тухай
3. Монгол улс байгуулах хорооны төсөл
4. Зэв сүмд “Монголын цэргийн засгийн газар” байгуулж, хөрөнгө гарган цэргээ цэгцлэн боловсруулаад Монголын төрөлх нутаг дэвсгэрээ эгүүлэн авах тухай төсөл
5. “Манж улс”-тай хамтран ажиллах хэлэлцээр байгуулах төсөл
6. Цэрэг татан хүчээ өргөтгөж, Монгол цэрэг байгуулах тухай төсөл
7. Аж ахуйн ажлыг нэгдмэл байдлаар явуулж эх баялгийг нээн ашиглах тухай төсөл
8. Монголын аж амьдралыг хамаарах хурал байгуулж, шинэ айл тосгоныг байгуулж тэтгэх төсөл, Хуадэ сянийг “Дэжуа” хот болгон өөрчилж, Цахарын чуулганаас гарган “Монголын цэргийн засгийн газар”-т шууд хамааруулах тухай төсөл ... зэрэг болно. (8, 116)

Хуралд Квантуны армийн зөвлөх Танака Такаёши, Ёкояма Осамо нар онгоцоор ирж оролцон үг хэлэхдээ “Чингис хааны үр ач нар олон жилийн турш хятадын дарлал мөлжлөгийг амсав. Японы их хаант улсын засгийн газраас монгол үндэстний хоцрогдонгүй байдлыг бодолхийлж, Монголын тусгаар тогтнон өөдлөн дэвжиж, Чингис хааны үйлсийг залгамжлахад тусалж өгнө..” гээд бүх хошууны ван гүн нарт гар буу бэлэглэсэн байна. Хурлын дайллага дээр Танака нь “Манж улсын Хянган хойт (Хөлөн буйр) мужийн Зинь Линшэн хувиараа Оростой харилцаад хаанд алагджээ” хэмээн ярьж төлөөлөгчдийг айлгасан байна. Квантуны армийнхан Хянган хойт мужийн дарга Линшэн нарын дөрвөн хүнийг “монголчууд нэгдэн тусгаар тогтнохоор хуйвалдаж, улсаас урвасан” (1, 57) гэсэн ял тулгаж 1936 оны 3 дугаар сарын сарын 26-нд цаазаар авсан байжээ. Дэ ван нар Японоос арван сая юанийн зээл авах тухай саналаа Такаёшид хэлэхэд Монголд газрын тос бий эсэхийг асуугаад энэ мэт уурхайн баялаг байвал ийм хэмжээний мөнгө зээлэх нь том асуудал биш гэсэн байна. Их хурал хамгийн сүүлд “Монголын цэргийн засгийн газрын зохион байгуулалтын хөтөлбөр”-ийг батлаад тэргүүлэгчээр Ёндонванчиг ванг, дэд тэргүүлэгчдээр Содномванжил ван Шагдаржав ван нарыг сонгожээ. Тэргүүлэгчид нь Дэ ванг ерөнхийлөгчөөр томилоод цэрэг засгийн эрхийг ганц түүнд атгуулсан байна.

Их хурлын ажилд идэвхтэй оролцсон У Хэлин-г япончууд ихэд анхаарч, урьд нь түүнийг устгахаар төлөвлөж байснаа больсон бөгөөд Дэ ван түүнийг нарийн бичгийн даргаар томилсон байна. Их хурлын шийдвэрийг үндэслэн Хуадэ сянь (Зэв сүм)-ийг Монголын цэргийн засгийн газрын суурьших газар болгож, нэрийг нь Дэ хуа (Эрдэм соёлт) гэж өөрчилсөн байна. Дэхуа хотод 5 дугаар сарын 12-нд Монголын цэргийн засгийн газар байгуулагдсанд зориулсан ёслол хийж, Чингис хааны он тооллыг хэрэглэх болж, улаан, шар, цагаан хөвөөтэй хөх тугийг Засгийн газрын туг болгов. Ёслолд бүх чуулган хошуудын төлөөлөгчид болон “Монгол цэргийн ерөнхий жанжин штаб”-ын хүмүүс оролцсоноос гадна Японы талаас Квантуны армийн штабын дэд дарга Имамура тэргүүтэй хүмүүс оролцжээ. Дэ ван, Имамура болон Манжаас Монголд суугаа төлөөлөгч зэрэг хүмүүс үг хэлж, Пу И-гийн ирүүлсэн баярын цахилгааныг уншаад шинээр томилогдсон албан тушаалтнуудыг танилцуулав. Дэ ванд ерөнхийлөгчийн хувьд дөрвөн туслагч томилж өгсөн нь Ли Шоусинь, У Хэлин, Буяндалай, Тогтох нар байв. 1937 оны 5 дугаар сард монгол цэргийн засгийн газрын харъяанд монгол цэргийн ерөнхий жанжин штаб байгуулж, даргаар нь Дэ ван, дэд

даргаар нь Ли Шоусинь-ийг, штабын даргаар УГулин-г томилов. Үүндээ 6 хэлтэс байгуулж, бүх дивизийг шууд удирдах болов. (9, 246)

“Монголын цэргийн засгийн газар” байгуулагдсаны дараах нэн чухал зорилт нь зэвсэгт хүчин байгуулах ажил болж, Дэ ван цэрэг татах болон агт худалдан авах ажилд биечлэн оролцсон байна. Хуучин байсан цэрэг дээрээ Шилийн гол Цахар хоёр чуулганы бүх хошуудаас шинэ цэрэг татав. Бүх цэргээ хоёр арми болгон хувааж, найман дивиз, нэг сэргийлэн хамгаалах дивиз, их бууны нэг хороо зэргийг байгуулав. Дарга удирдлагуудыг нь томилж, Дэ ван өөрөө хоёрдугаар армийг хавсран удирдах болсон байна. Цэргийн зардал, буу зэвсгийн ихэнхийг Квантуны армиас хангаж, сар бүр гучин сая иен, дайны нөхвөр зардал 300 мянган иен байхаар тогтоосон байна. Армиас суман хүртэлх нэгжүүдэд япон зөвлөх, сургагч нар байхаар тохиров. Сөнид баруун хошуун дахь Дэ вангийн ордны зүүнтээх цэргийн хуаранд “Монгол цэргийн даргын сургууль”-ийг тусгайлан байгуулж, Дэ ван өөрөө хавсран удирдах болжээ. Цэргийн сургалтыг хэдэн сарын турш тун шаргуу явуулаад 9 дүгээр сард Дэхуа хотын онгоцны буудал дээр цэргийн жагсаалын том үзүүлэх сургууль зохион байгуулж, монгол цэргийн “зэвсгийн эрдэм”-ийг япончуудад үзүүлэхээр шийдвэрлэв. Энэ сургуульд голдуу Дэ вангийн шууд удирдлагад байсан хоёрдугаар армийн монгол цэргүүд оролцсон бөгөөд Итагаки Сэиширо онгоцоор зориуд ирж үзээд сургалтын амжилтад тун сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлжээ.

Дараа нь Дэ ван тэргүүтэй удирдах хүмүүс хоёр онгоцоор “Манж улс”-ын шинэ нийслэл Чанчуньд очиж, Квантуны армийн штабын даргатай уулзаад дараа нь “Манж”-ийн ерөнхий сайд, Гадаад харилцааны, Цэргийн болон Монголын засгийн явдлын яамны сайд нартай уулзаж ярилцав. Дараа нь Гадаад харилцааны яамтай нь эв хамт намыг хамтаар эсэргүүцэх, цэргийн салбарт хамтран ажиллах, харилцан төлөөлөгч томилох, эдийн засгийн хамтын ажиллагаа өрнүүлэх зэрэг агуулга бүхий “Монгол-Манжийн гэрээ”-г байгуулав. Энэ гэрээ ёсоор хоёр тал харилцан төлөөлөгч томилон суулгаж, “Манж улс”-ын төв банк Дэхуа хотод салбараа байгуулан Манжийн цаасан мөнгийг тарааж гүйлгээнд оруулсан байна. (8, 127)

Дараа нь Дэ ван “Манж улс”-ын Энх эрдэмт хаан Пу И-д бараалхав. Тэрээр урьд нь Пу И-тэй хоёр ч удаа уулзаж, ёс төр гүйцэтгэж байсан бөгөөд энэ удаа өөрийн үйл ажиллагааны байдлыг танилцуулаад япончуудтай хамтран ажилласнаар амин чухал олон асуудлаар бие даан шийдвэр гаргаж чадахгүй болсноо хэлсэн байна. Мөн үүний

зэрэгцээ япончуудын харгис хэршгий ажиллагаа явуулж буйд дургүйцэж явдгаа илэрхийлжээ. Пу И нь япончуудын зөвлөснөөр Дэ ванд “Баатар Дэмчигдонров чин ван” гэсэн зарлигаар өргөмжилсөн бичгийг гардуулж өгчээ.

Дараа нь Гадаад харилцааны захиргааны дарга Тогтохыг томилон явуулж, “Хэбэйн зүүн мужийн эв хамт намаас сэргийлэх өөртөө засах засгийн газар”-ын хүмүүстэй уулзуулж, улс төрийн талаар эв хамт намаас хамтаар сэргийлж, эдийн засгийн талаар хамтран ажиллах санааг багтаасан “Монгол-Хэбэйн гэрээ”-г байгуулсан байна. Энэ гэрээг үндэслэн Танака Такаёши дээр дурдсан “засгийн газар”-тай харилцан нэг сая юань олж “Монголын цэргийн засгийн газар”-т тусалжээ. (2, 27)

Квантуны арми “Монголын цэргийн засгийн газар”-ыг хязгаарлах явдлаа чангатгах зорилгоор 1936 оны 10 дугаар сард Танака Такаёши-г Дэхуа хотын тагнуулын байгууллагын даргаар томилжээ. Ингээд Япончууд Суйюань мужийг монгол цэргээр довтлуулахаар Дэ ванг ятган, үүнийгээ хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж эхлэв. Энэ үед Ван Ингийн зохион байгуулсан “Их хятадын журмын цэрэг” гэгч байгуулагдаад байв. Танака Такаёши Суйюанийг эзлэхдээ Ван-гийн цэргийг түрүүнд нь оруулж, хятадыг хятадаар нь цохиулвал монгол цэрэг хохирохгүй хэмээн Дэ ванг ятгаж зөвшөөрүүлэв. Ван-гийн уг нутаг нь Суйюаний Бор тохой байсан тул цэргийг нь хөдөлгөхөд төвөггүй байжээ. (6, 22) Довтлох монгол цэргийн штабыг Дэ ван өөрөө удирдах болж, Зодовжавыг дэд даргаараа томилон. Ингээд довтлох төлөвлөгөөг боловсруулж дуусаад Дэ ван нар Суйюань мужийн засгийн газрын тэргүүлэгч Фу Зуои-д дайн зарлах тухай цахилгаан илгээсэн байна. Түүндээ тус муж монголчуудаас хураасан гаалийн татвараа хуваалцдаггүй, өөртөө засахыг эвдэж монголчуудыг хөнөөсөн, амрыг хамгаалах ангийн цэргүүдээс урвуулан аваад дараа нь хэдэн зуугаар нь алсан, хутган үймүүлснээс болж “Монголын засгийн явдлын зөвлөл”-ийг сүйрүүлсэн зэргийг дурдаад “монголчууд найр тавих тутам эрхэм муж улам дарлаж, эдүгээ тэсвэрлэхүйеэ бэрх болсон тул ард түмэн зэвсэгт хүчнээ ашиглахад хүрэв” гээд таван зүйлийн шаардлага тавьсан байна. (9, 279)

Гурван хоногийн дараа Фу Зуои дурдсан таван шаардлагыг нь няцаасан агуулгатай цахилгаан ирүүлсэн бөгөөд тэрээр эл байдлыг Зян Зиэши-д уламжилсан байна. Зян Зиэши мөн Дэ ванд цахилгаан ирүүлж, түүний өдөөсөн хэргийг зэмлэн буруушаасан байв. Гэтэл энэ үед Дэ ван Ли Шоусинь нарын удирдсан монгол цэрэг болон Ван Ингийн толгойлсон “Их хятадын журмын цэрэг” япон зөвлөхүүдийн

захиргаан дор Суйюаний зүүн талын Хонгорт зэрэг газар руу нэгэнт дайралт хийсэн байв. Арван нэгдүгээр сарын 14-д эхэлсэн дайралтад японы нисэх онгоцууд оролцож, Ван Ин-гийн цэргүүд тэргүүн эгнээнд дайтаж, ард нь монгол цэргүүд хянаж байв. Гурван өдрийн турш тулалдаж, Суйюаний тал 35 дугаар армиар дэмжүүлэн дайралтыг няцаасан байна. Энэ тулалдаанд ялагдал хүлээгээд Танака Такаёши нар Суйюань мужийн хойт хэсгээр довтолхоор төлөвлөв. Дэ ван энэ үед Мүгдэнбуугийн захирч байсан долдугаар дивизийг Бат хаалга сүмээс гаргах гэсэнд хоёрдугаар армийн япон зөвлөх тас хориглож, сүмийг хамгаалуулахыг тушаасан байна. Ингээд зуу гаруй машинаар хоёр мянгаад цэргийг Бат хаалгад аваачаад дахин 200 гаруй машинаар таван мянгаад цэрэг тийш нь шилжүүлэхээр төлөвлөж байв. Гэтэл Суйюаний тал 35 дугаар армийн ангиудын хүчээр Бат хаалга сүмийг баруун зүүн талаас нь зэрэг довтолж эхлэхэд тэнд сууж байсан мянга гаруй ламыг хүртэл дайчлан байлдсан боловч амжилт олсонгүй. Ингээд Бат хаалга сүм Фу Зуои-гийн цэрэгт эзлэгдэв. (6, 26) Бат хаалга сүмийг хамгаалж байсан монгол цэргийн долдугаар дивиз бут цохигдсоныхоо дараа Дөрвөд хошууны ойролцоох Шар мөрөн сүмд цугларч эгнээгээ дахин цэгцлэв. Танака Ван Ин-гийн цэргийн үлдсэн хэсгийг цуглуулж, Бат хаалга сүм рүү дахин дайралт хийсэн боловч амжилт олсонгүй. Ван Ин-гийн цэргийн хоёр бригадын дарга Фу Зуои-гийн цэрэгтэй холбоо тогтоож бослого гарган япон зөвлөх зэрэг 27 хүнийг буудан алж, Мүгдэнбуугийн долдугаар дивизийг гэнэт дайран бүх зэвсгийг нь хураасан бөгөөд эсэргүүцсэн хэдэн зуун монгол цэргийг устгасан байна. (8, 143) Энэ хэрэг явдлын үеэр долдугаар дивиз бүрмөсөн сүйрч, хоёр мянгаад цэрэг алагдсан гэж зарим судлаач бичсэн байдаг.

Дэхуа дахь Японы тагнуулын газрын дарга Такаёши удирдан хийлгэсэн байлдааны ажиллагаанууд нь амжилтгүй болсон шалтгаанаар албан тушаалаасаа 1937 оны эхээр өөрчлөгдөж, оронд нь Такаифу Акира гэгч томилогдон ирэв. Тэрээр монгол цэргийг цэгцлэх талаар зөвлөлдөхдөө есөн дивизийг зургаа болгож, дивиз бүрт нэг их бууны суман байгуулах санал тавьсанд цэргийн хүчиндээ түшиглэн Монголыг нэгтгэх бодолтой байсан Дэ ван их бууны сумантай болгохыг нь зөвшөөрч, дивизийг цөөрүүлэхийг зөвшөөрсөнгүй. Төдөлгүй Акира буцаж Дэхуа-гийн тагнуулын даргаар Кавасэки Таишэкай томилогдон ирлээ. Монгол цэргийн чадавхийг дээшлүүлэхийн тулд япончууд шууд оролцон “Монгол цэргийн ерөнхий жанжин штаб”-ыг байгуулж, Дэ вангаар захируулсан бөгөөд Ли Шоусинь дэд дарга нь болж, харьяанд

нь зургаан газар байгуулжээ. Урьдын хоёр армийн бүтцийг өөрчилж, бүх дивизүүд шууд ерөнхий жанжин штабтаа захирагдах болов. Хэд хэдэн дивизийн удирдлагуудыг өөрчилж, сүйрсэн долдугаар дивизийн дарга Мүгдэнбууг халсан байна.

Япончууд 1937 оны 7 дугаар сарын 7-нд “Лу гоу цяо”-гийн хэрэг явдал”-ыг үүсгээд хүчээ төвлөрүүлэн Бээжин, Тяньжин рүү довтлохын тулд Цахар, Суйюанийг хайхрахаа больж түр орхисон байна. Энэ үеэр Фу Зуои-гийн цэрэг Цахарын хойт хэсэгт суурьшиж байсан монгол цэргийг дайрахад Дэ ван нар Квантуны армиас тусламж гуйсанд тэд Танака Такаёши-г Солонгосоос дуудан Дэхуа-д томилж, цэргийн хэргийг хариуцуулжээ. Дэ ван “Монгол цэргийн засгийн газар”-аа Долон нуурт шилжүүлэхийг тушаагаад өөрөө онгоцоор Сенид баруун хошуун дахь ордондоо очив. (9, 316) Урьд нь Дилав хутагт түүнд “Чи хэрэв Японтой хамтран ажиллаж чадахгүй бол эртхэн явах хэрэгтэй. Дэлхийн бүх улсаар тойрон Монголын байдлыг ухуулж, энэ асуудлыг дэлхийн улс төрийн тавцан дээр аваачиж, олон улсыг түшиглэн Монголын асуудлыг шийдвэрлэх нь ганц Японыг түшиж шийдсэнээс дээр...” гэж хэлж байсныг Дэ ван энэ үед санав. Дилав хутагтын энэ үг зүйтэй юм шиг санагдахад нь тэрээр У Хэлин-тэй зөвлөж, Японтой дахин хамтран ажиллахаа больж, хошуундаа очоод дахин сайн бодох гэсэн боловч У Хэлин “Японы цэрэг Бээжин, Тяньжинг эзэлчихлээ. Удахгүй Өвөр Монголд цэрэг оруулах байх. Тэднийг орж ирсэн хойно хамтарвал санаачилгагүй байдалд орно. Тиймээс одоо хорших нь дээр. Хожим цагийн байдлыг ажиглаж байгаад арга бодож болно шүү дээ” гээд энэ бодлоо орхихыг зөвлөсөн тул хүмүүсээ цуглуулж, хүчээ дахин цэгцлээд Долон нуур дахь сүмдээ ажиллаж эхлэв.

“Лу гоу цяо”-гийн хэрэг явдлын дараа 7 дугаар сарын 11-нд япончууд Хятадын хойт хэсэгт цэрэг оруулахаар шийдвэрлэж, Квантуны армийн Сэиширо-гийн цэрэг Чуулалт хаалга тийш довтолж эхлэв. Мөн Тозиёо-гийн шилмэл ангиуд Долон нуур, Жанбэй-гаар дайран Чуулалт хаалгын араас дайралт хийж, 24-нд эзлэн авсан байна. Дараа нь Мүгдэн, Бээжин, Суйюаний хоорондох төмөр зам дагуу баруун тийш довтлов. Есдүгээр сарын дундуур Датуныг эзлээд, Тайюань тийш дайралтаа үргэлжлүүлсэн бөгөөд энэ үед Тозиёо онгоцоор Чанчуньд очиж, ЗХУ-тай байлдахаар бэлтгэж эхэлсэн байна. Суйюанийг довтлох япон, монгол, манж цэргийг Сакай удирдаж, Фу Зуои-гийн цэрэг ухрах үед Дэ ван нар Долон нуурт сууж, монголоор бичсэн нууц цахилгаанаар дивизүүдээ удирдаж байв. Ли Шоусиний удирдсан хэсэг монгол цэрэг

Зининь-ийг эзлэн авсан байна. Япончууд Бээжин, Тяньжинг маш түргэн эзлэн авч, 8 дугаар сарын 13-нд Шанхай руу чиглэн Хятадыг түрэмгийлэх дайнаа бүх талаар эрчимжүүлэв.

Энэ үеэр Дэ ван, У Хэлин, Тогтох нар Долон нуураас “Монголын цэргийн засгийн газар”-ын удирдах ажилтнуудаа дагуулан Жанбэйд ирж, гол хүмүүсээ дахин өөрчлөх үедээ хамгийн итгэлтэй, идэр залуу хүмүүсээ албан тушаалуудад томилжээ. Тэрээр хэсэг ажилтнуудынхаа хамт Шилийн гол ба Бат хаалга сүмийн ойр хавиар явж, бүх хошууны амрыг хамгаалах ангийг цуглуулж, “Монголын чуулган хошуудын холбоот цэрэг”-ийг зохион байгуулахын хамт есдүгээр дивизийн цэрэгтэй хамтран Суйюань мужийн төв Гуйсуй (одоогийн Хөххот)-г эзлэхээр төлөвлөсөн байна. Зининь-ийг эзэлсэн монгол цэрэг япончуудаас нэлээд тасарч, давшилтаа үргэлжлүүлэн Гуйсуйг эзлэхээр хөдлөхөд нь япончууд цэргээ гүйцэж иртэл хүлээлгээд 10 дугаар сарын 14-нд хамтаар довтлон эзэлжээ. Бугатыг 17-нд эзлэн авав. Ингээд У Хэлин, Тогтох нар “Монголын цэргийн засгийн газар”-аа Жанбэй-гаас Гуйсуй-д шилжүүлэн авчраад Бат хаалга сүмд байсан Дэ ванд цахилгаан явуулахад тэрээр онгоцоор одоогийн Хөх хотод ирсэн байна. (9, 324)

Дэ ван нар Гуйсуй хотод хоёр дахь удаагийн “Монголын их хурал”-ыг хуралдуулж шинэ засгийн газар байгуулахаар тохиролцож зар тараав. Их хуралд “Монголын цэргийн засгийн газар” болон “Монгол цэргийн ерөнхий жанжин штаб”-ын бүх байгууллагуудын удирдлага, Өвөр Монголын баруун орны бүх чуулган хошуудын ван гүн нарыг нэр заан дуудсанаас гадна урьд нь Суйюань мужид орж байсан хот, сүний удирдлагуудыг оролцуулсан байна. Мөн япон зөвлөхүүд, Гуйсуй хот дахь Японы тагнуулын байгууллагын дарга, “Манж улс”-ын төлөөлөгч, Цахар, Шаньси-д шинээр байгуулагдсан “засгийн газар”-уудын төлөөлөгчид оролцов. Япончууд энэ үед тэдэнд бууж өгсөн хятадуудыг ашиглан Чуулалт хаалгад “Өмнөд Цахарын өөртөө засах засгийн газар”, Датунд “Умард Шаньси-гийн өөртөө засах засгийн газар” гэгчийг тус тус байгуулаад байв. Бэлтгэл хуралдааны үед Дэ ван нар тусгаар тогтносон Монгол улс байгуулах санал дэвшүүлэхэд япончууд элдэв тайлбар хийгээд зөвшөөрөхгүй байлаа. Тэд “Монголын цэргийн засгийн газар”-ыг Цахар, Шаньси-гийн “засгийн газар”-уудтай тэгш эрхтэй байлгахыг зорьсон байжээ. Монголчууд дахин судалж ярилцаад “Монголын хамтарсан өөртөө засах засгийн газар” байгуулах хөтөлбөрийг боловсруулжээ. Түүндээ уг засгийн газар нь тэргүүлэгч, дэд тэргүүлэгчтэй байх ба доор нь Засгийн явдлын хороо байгуулж, дарга нь засгийн ажлыг хамаарах, Монгол цэргийн

ерөнхий жанжин штаб нь цэргийн хэргийг хариуцахад тусгав. Гуйсуй хотыг уг засгийн газрын төв болгож, нэрийг нь Хөххот гэж өөрчлөхөөр тогтжээ. Төслийг япончуудад танилцуулахад үндсэнд нь зөвшөөрч, харин дэд тэргүүлэгчтэй байхыг хүлээн аваагүй байна. Тэд Дэ ванг Засгийн явдлын хороон дарга, Ли Шоусинь-ийг Монгол цэргийн ерөнхий жанжин штабын дарга болгохоор бодсон байжээ. Энэ саналыг Дэ ван нар олон талаас нь шүүн ярилцаад дотоодын зөрчил гарахаас сэргийлэх үүднээс зөвшөөрөх нь зөв гэж шийдэв.

Төлөөлөгчид цуглахад бэлтгэл хуралдаан хийж, Ёндонванчиг ван, Шагдаржав ван, Дэ ван, Ли Шоусинь, Зодовжав, Бавуудорж, У Хэлин, Жаргалан нарыг тэргүүлэгчдээр сонгоод 10 дугаар сарын 27-нд их хурал эхлэхэд Квантуны армийн штабын дарга Тозиёо онгоцоор ирэв. Их хурал “Монголын өөртөө засах хамтарсан засгийн газрын зохион байгуулалтын хөтөлбөр”, “Түр хэрэглэх зохион байгуулах хууль”, “Хоёр дахь удаагийн Монголын их хурлын тунхаг”-ийг хэлэлцэж батлав. Хурлаас Ёндонванчиг ванг тэргүүлэгчээр, Дэ ванг дэд тэргүүлэгчээр сонгон баталсан байна. Сүүлд нь Япон ба “Манж”-д илгээх талархлын цахилгааныг нийтлэв. (3, 17)

Ёндонванчиг ван Их хурлын тэргүүлэгчээр сонгогдсон боловч Дархан хошуун дахь ордондоо сууж, өвчнөөр шалтаглан хүнтэй уулзахгүй байсан бөгөөд их хуралд ч ирж оролцсонгүй. Дэ ван дэд тэргүүлэгчийг хавсарсан Засгийн явдлын хорооны даргын албан тушаалдаа орж, засгийн газрын бүх ажил хэргийг ерөнхийлөн хамаарч байв. Засгийн явдлын хорооны харьяанд Ерөнхий явдлын, Эдийн засгийн, Амрыг хамгаалахын гэсэн гурван яам байгуулж, тэдгээрийн дотор олон газруудыг байгуулжээ. Мөн Хууль цаазын товчоог нэмж байгуулав. Квантуны арми Монголын засгийн газрын бүх шатны байгууллагуудыг чанд хянах зорилгоор зөвлөхийн албыг тусгайлан байгуулсан байна. Дэ ван Ли Шоусинь-ийг Монгол цэргийн ерөнхий жанжин штабын даргаар, У Хэлин-г Зөвлөлгөөний комиссын даргаар гэх мэт олон томилгоо хийжээ. Ингээд тэр Японы дэмжлэгтэйгээр “Монголоо мандуулах”, “Тусгаар тогтносон улс байгуулах” зорилтоо биелүүлэхийн төлөө тун зоригтой ажиллаж эхлэв.

Монголын засгийн газрын тэргүүлэгч байсан Ёндонванчиг ван 1938 оны 3 дугаар сард нас барж, тэргүүлэгчийн тушаалыг залгамжлуулах хүнийг сонгохоор 7 дугаар сард гуравдахь удаагийн Монголын их хурлыг хуралдуулав. Их хурал Дэ ванг засгийн газрын тэргүүлэгчээр сонгож, Засгийн явдлын хорооны даргын албан тушаалыг

хавсаргасан байна. Тэрээр засгийн газартаа зохион байгуулалтын зарим өөрчлөлт хийж, нэг тэнхим, дөрвөн яамтай болгохын хамт доод шатанд шинээр зарим нэгжүүдийг буй болгов.

“Монголын хамтарсан өөртөө засах засгийн газар” байгуулагдсаны дараа Дэ ван ноёлох байр сууриа бэхжүүлж, засгийн газрын зохион байгуулалт, цэргийн хэрэг, соёл, боловсролын зэрэг чиглэлээр зүйл бүрийн шинэчлэл хийснээс гадна бүх чуулган хошууны засаг захиргааны бүцийг ч бүрэн төгөлдөр болгов. Нэлээд олон хошуу, саяниудын захиргааг өөрчлөн, шинээр Баян талын чуулганыг байгуулж, даргаар нь өөрийн шадар хүн Буяндалайг томилов. Хөххотоос гадна төвд шууд захирагдах Бугат хотыг байгуулжээ. Ийм өөрчлөлтүүд хийсний дараа таван чуулган, хоёр хоттой болж, нийт нутаг дэвсгэр нь 350 мянган хавтгай дөрвөлжин километр, хүн ам нь 2.5 саяд хүрсэн байна. Үүний дотор монгол үндэстэн бараг 300 мянга болж, нийт хүн амын 12 хувийг эзлэх болсон бөгөөд хотон үндэстэн 37 мянга байв. (9, 368) Хошуу саян зэрэгцэн оршиж, монгол хятад иргэд холилдон суусан газар нутгуудад Дэ ван Бээжин Суйюаний төмөр замаар зааг болгон монгол хятадыг салган суурьшуулахаар төлөвлөжээ. Ингээд монгол ардыг хошуунд, хятадуудыг нь саянд харьяалуулан зааглахаар шийдсэн байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Алтандалай “Япон ба Өвөр Монгол” Хөххот, 2005
2. Дэмчигдонров.Н “Хуурмаг Монголын цэргийн засгийн газар байгуулагдахын өмнө хойно” Хөххот, 1964
3. Дэмчигдонров. Н “Хуурмаг Монголын хамтарсан өөртөө засах засгийн газрын үүсэл төгсөл” Хөххот, 1964
4. Zha qi xi qin “Wo suo zhidao de De wang he dang shi de Nei menggu” Beijing, 2005
5. Ли Тайфэн “Хуурмаг Монголын өөртөө засах холбоот засгийн газрын товч” Хөххот, 1974
6. Ли Тайфэн “Ван Ингийн ялт түүх” Хөххот, 1981
7. Лу Минхуй “Ба Вэньюанийг сурвалжилсан тэмдэглэл” Хөххот, 1973
8. Lu Minghui “De wang qi ren” Huhe haote, 1998
9. Лу Минхуй “Монголын өөртөө засах хөдөлгөөний эхлэл төгсөл” Хөххот, 1986
10. Түвшин “Дэмчигдонровын тоочилт” Хөххот, 1991